

Монгол хэлний “охин” гэдэг үгийн гарал, хувьсал

*МУБИС-ийн МоСС-ийн Монгол хэл шинжлэлийн
тэнхимийн багш, доктор (Ph.D) Д.Соронзон*

Монгол хэлний “охин” гэдэг үг нь бусад эшийн нэрийг бодвол харьцангуй хожуу үүссэн боловч утга, бүтцийн үлэмжхэн хувьсалд орсон өвөрмөц сонин үг юм. Энэ үгийн гарал, түүхэн хувьслыг илтгэж чадах тодорхой жишээ баримтууд дундад үеийн монгол хэл хүртэл тогтвортой хадгалагдсаар ирсэн бөгөөд түүнээс үүдэж хийсэн ажиглалтаа тус өгүүлэлд тайлбарлалаа.

Урьдаар энэ үгийн гарлын талаарх эрдэмтэн судлаачдын саналыг авч үзье. Үүнд, Өвөрмонголын судлаач **Намсрай**: “**Охин гэдэг нь этүгэн, удам, ураг гэх үгстэй гарлын харьцаатай байж магад**” (8:46) хэмээн үзжээ. Проф. **М.Базаррагчаа**: “**Бө-жи-ий-кү, бө-жинг**” зэрэг үгээс “**ү-жи-н**” /Өөлөн үжин/ хэмээх үг үүссэн байж болох юм. Энэ нэр нь охидыг “**бөжин**”-тэй зүйрлэн нэрлэж байснаа, эрхэмсэг хатдын дагалт нэр болсон байж болох юм” (1:331) гэсэн бол Өвөрмонголын судлаач **Хасбаатар**: “**Охин ба өгий (Mo. ögüi) гарал нэгтэй байсан бөгөөд түүний нийт дундын хэлбэр нь бараг “*ükün” байсан магад. Тэгээд “*ükün”-ээс “*ököi” ба “*ökin” гэсэн хэлбэр хөгжин гарч, утгын талаар ч адил бус хуваарилалттай болжээ**” (12:24) хэмээн тэмдэглэсэн байна. Бас эрдэмтэн **Сэцэнцогт**: “**Охин, өгүй гарал нэгтэй бололтой**” (10:443) гэх зэргээр үзсэн байна.

Дээрх судлаачдын ажиглалт, саналуудыг үзвэл, ихэвчлэн таамаг төдий нь нийтлэг бөгөөд түүхэн хувьслыг харгалзан тогтоосон зүйл бараг алга байгаа тул энэ үгийг төрөл хэлний баримтаас харьцуулан нягталъя.

Уул үгийг монгол бичигт “ökin” хэмээн тэмдэглэнэ. Харин эртний түрэг хэлэнд qiz (5:449), орчин үеийн түрэг хэлнүүдэд kiz ~ giz (14:484-485), манж хэлэнд sargan jui (16:386) гэх зэрэг хэлбэртэй байдгаас үзвэл, “охин” гэдэг үг бол бие даасан монгол хэл хэлэнд үүссэн нь илэрхий учир энэ хэдэн үгийг гарлын холбоогүй хэмээн ойлгож болно.

Харин одоо монгол хэл, бичгийн баримтаас нягтлан үзье. Дундад үеийн монгол хэлний дурсгалуудад “öke” хэмээх нэгэн хэлбэр тохиолдох ба тэр нь “эх” гэсэн утгатай. (9:83) Үүнээс бид тухайн цаг үед “эх” гэдэг үг бүтцийн хувьд eke > öke болж хувьсаад байсныг мэдэж болохоор байна.

Түүний дараа “öke” гэдэг үгийн тэргүүн үеийн “ö” эгшгийн нөлөөгөөр эцсийн “e” эгшиг нь уйтаншиж “i” болсноор “öki” гэсэн хэлбэртэй болжээ. Энэ үед утга нь ч мөн хамт хувьсаж, охин хүүхдийг заадаг болсон байна. Жишээлбэл, “Монголын нууц товчоо”-ны 54-р зүйлд: “**Merkid-ün Yeke-čiledü Olqunu'ut irgen-eče öki abču**” (15:34) гэхэд жинхэнэ нэрийн үүргээр буюу бие даасан эшийн нэр болж хэрэглэгджээ. Эдүгээ Шинжааны Ойрд аялгуунд энэхүү “öki” бүтэц хэвээрээ үлдсэн боловч “авга эгч” гэсэн утгатай болсон (6:85) бол “охи” гэсэн хувилбар нь харин Үзэмчин аялгуунд “охин” гэсэн утгаа хадгалан хэрэглэгдэж байна. (3:257)

Гэтэл “Монголын нууц товчоо”-ны 65-р зүйлд “*nu'un kö'üt manu nuntuq qarayu ökin kö'ün manu öngge üjegdeyü*” (15:39) гэснээс үзвэл, энэ үг “нуган” гэдэг үгтэй эсрэгцсэн буюу “эмэгтэй” гэх утгатайгаар, тэмдэг нэрийн үүрэгтэй хэрэглэгдсэн байна. Энэ нь даруй тэмдэг нэр бүтээх “-н” дагавраас шалтгаалсан хэрэг бөгөөд үүнтэй тун ойр жишээ татвал, өмнө дурдсан өке “эх” хэмээх үгэнд уул дагаврыг залгахад *öken* [**öke(n)*] “эмэгтэй” гэсэн (9:83) үг бүтэж байсан нь бичгийн дурсгалд мөн тэмдэглэгджээ.

Ингээд эцэст нь *ökin* хэмээх хэлбэр холбогдож байсан үгийнхээ үүргийг өөртөө шингээснээр бие даасан эшийн нэр болж тогтсон тул хожмын тайлбар толь бичигт: “1. эм; *охин хурга; охин унага*; 2. эмэгтэй үр хүүхэд” (13:427) хэмээн тайлбарлах болсон байна. Өөрөөр хэлбэл, монгол бичгийн хэлэнд буй *ökin* “охин” бол үүргээ алдсан тэмдэг нэр бүтээх “-н” дагавар бүхий хэлбэр юм.

Цаашлаад орчин үеийн монгол хэл, аялгуунуудад уул үг яаж хувьссаныг хянан үзвэл, бүтцийн өвөрмөц хувьсал бүхий сонирхолтой баримтууд элбэг тохиолдож байна. Жишээ нь, *Barin. jixen* (17:396), *Khar. ixan* (17:396), *Bao. okuŋ* (2:4), *SY. hgon* (17:396), *Dag. üdžin ~ ügin* (17:396) *üjin* (4:49), *Dun. otšin* (17:396) гэх мэт. Энд дараах түүхэн хувьслууд ажиглагдана. Үүнд:

1. Тэргүүн үеийн эгшиг нь дараа үеийнхээ эгшигт татагдан ижилсэж, уйтаншсан.
2. Баоань хэлэнд тэргүүн бус үеийн *i* нь *u* эгшигтэй сэлгэсэн нь дундад үеийн монгол хэлний дурсгал “Ибн Муханны толь”-д буй *ökün* “охин” (11:105) хэмээх үгийн хувьсалтай ойролцоо юм.
3. Үгийн эхэнд гийгүүлэгч нэмэгдсэн.
4. *k > tš* буюу *g > dž > j* гэсэн хувьсал гарсан. Дунсян хэлэнд “*otšin*” гэсэн хэлбэртэй болсон бол Дагур хэлэнд “*üdžin*” болжээ. Дагур хэлний жишээний хувьд “*ügin*” гэсэн хэлбэрээс үүссэн нь гарцаагүй бөгөөд энэ үг хятад хэлнээс нэвтэрсэн “фу-жень” зэрэг харь үгийн түүхэн улирал биш¹, харин ч уугуул монгол хэлний үг болохыг харуулсан тодорхой жишээ байна. Энэ үгийн нөгөө хувилбар нь монгол хэлний *ögüi* [**öge < *ege*] “өгий”² бөгөөд төрөл хэлнүүдийн хувьд *ugi* (Ew.), *oi ~ oji ~ ögi* (Ev.) “бэргэн” гэх мэтээр тохиолддог. Ташрамд манж-түнгүс хэлний эдгээр үг нь нэн эртний гарлын холбоотой болно. “Монголын нууц товчоо”-нд энэхүү “*üjin*” гэдэг үг *Hö'elün üjin*, *Börte üjin* болон мөн 177-р зүйлд: “*Toqto'a-da Nuja'ur üjin ökin-iyen ni'urqan ökcü*” (15:132-133) хэмээн гурван хүнтэй холбоотойгоор хэрэглэгддэг бөгөөд сүүлийн жишээнд “охин” гэдэг үгтэй хамт орсноос үзвэл, энэ “үжин” хэмээх нь ямар нэг язгууртны охин хүнд хамаатай нэр болсон байжээ. Хэрэв энэ үг хятад хэлнээс нэвтэрсэн

¹ *Эрдэмтэн Ш.Гаадамба дунд үеийн монгол хэлний “үжин” гэх үгийг Пүдин нэрт эмэгтэйн нэрээс үүссэн бөгөөд “пүдин → фүдин → фүджин → үжин” гэж үүссэн хэмээн авч үзжээ. (7:248)*

² *Энэ үгийн утгыг “Монгол хэлний товч тайлбар толь”-д: “1. Эгч; өгий эгч х о р ш.; 2. Эмэгтэй хүнийг дуудах хүндэтгэл;” хэмээн тайлбарлажээ. (13:431)*

үг мөн бол үгийн эхний гийгүүлэгчийн $f > x > h$ гэсэн хувьслын аль нэг үе шатыг хадгалан үлдсэн байх ёстой билээ.

Дүгнэлт

Гарал, утга, бүтцийн талаас нь ажиглавал, “охин” гэдэг үг бие даасан монгол хэлэнд үүссэн буюу хэлний хөгжлийн харьцангуй хожуу үед үүссэн боловч хувьслын нэлээд олон шатыг дамжиж бидний үед иржээ. Баримтаас үзэхэд, монгол бичгийн хэлний “ökin” хэмээх хэлбэр нь еке “эх” > öke “эх” > öki “охин хүүхэд” > ökin “эмэгтэй” > ökin “охин хүүхэд ба эм хүйст” гэсэн дарааллаар хувьссан байна. Түүнчлэн еке (~ ege) бүтцийн тэргүүн үеийн эгшиг ö (öki, ögüi), ü (*ügi > ügin > üjin), o (oxi) авиагаар сэлгэсэн нь энэ үг эх, эгч, өгий, эхнэр зэрэг үгтэй нэг гаралтай буюу дан ганц эгшгийн ондоошил төдийхнөөр дундад үеийн монгол хэлэнд тохиолдож байсан хэлбэрээ олсон байна.

Abstract

Mongolian language “daughter” has founded later that compares other kinship terms. This word is specific meaning and structure that depending on giant interesting and revolution. The Etymology and historical renovation can be shown what certain patterns have been until middle period of Mongolian linguistics. Otherwise, in my opinion, the observation was explained in the story.

Etymology and evolution of Mongolian word “daughter”

Номзүй

1. Базаррагчаа, М., Монгол үгийн гарлыг мөшгих нь. IV, V. Уб., 1994, 711 х.
2. Баоань хэлний үгс, Монгол төрлийн хэл аялгууны судлалын цуврал, 011, ӨМАХХ, 1985, 239 х.
3. БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг: Халх аялгуу, 1. Уб., 1988, 718 х.
4. Дагур хэлний үгс, Монгол төрлийн хэл аялгууны судлалын цуврал, 005, ӨМАХХ, 1984, 337 х.
5. Древнетюркский словарь, Л., 1969, 677 с.
6. Лүнтүү., Ойрд нутгийн аялгууны үгсийн хураангуй, Хөххот, 1994, 246 х.
7. Монголын нууц товчоо, Худам монгол бичгээр сийрүүлсэн Ш.Гаадамба, Уб., 1990, 422 х.
8. Намсрай, Монгол хэлний төрөл садны дуудлагуудын учир утга, - МХБ. 7(1991), 40-49
9. Рыкин, П. О., Семантический анализ терминов родства и свойства в среднемонгольском языке, - ВФ. Серия “Урало-алтайские исследования”. 1(2009), 80-91
10. Сэцэнцогт., Монгол үгсийн язгуурын толь, ӨМАХХ, 1988, 2972 х.
11. Төмөртоого, Д., Араб үсэгийн монгол дурасгалын судалгаа, Уб., 2002, 172 х.
12. Хасбаатар, Монгол хэлний төрөл садны зарим нэрийдлийн үүслийн тухай, - МС. 1(1993), 16-28
13. Цэвэл, Я., Монгол хэлний товч тайлбар толь, Уб., 1966, 911 х.
14. Karşılaştırmalı Türk Lehçeleri Sözlüğü, I, Ankara, 1991, 1183 p.
15. Ligeti, L., Histoire secrete des Mongols, Budapest, 1971, 265 pp.
16. Manchu-Chinese-Mongolian Trilingual Dictionary of by 1780 Arranged by Mongolian Words, Compiled by H.Kuribayashi & Hurelbator, Sendai, 2006, 640 pp.
17. Sun Zhu., Menggu yuzu yan cidian, Qinghai, 1990, 844 p.